МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2017.06.15 № 781

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДЭД

Сургалтад нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлөөс Бүгд Найрамдах Казакстан Улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай харилцаа тогтоож, хамтран ажиллаж байгаа бөгөөд манай хүсэлтийг дэмжиж тус улсын Ерөнхийлөгч Н.Назарбаевын нэрэмжит тэтгэлгээр Монгол Улсаас 2 төрийн албан хаагчийг тус улсын Төрийн захиргааны академид (The Academy of Public Administration under the President of the Republic of Kazakhstan) магистрын зэрэг хамгаалах 1 жилийн тусгай хөтөлбөрт сургалтад 2016-2017 онд хамруулсан бөгөөд хөтөлбөр үргэлжлэх хүрээнд 2017-2018 онд "Бүс нутгийн хөгжил" сэдвээр магистрийн зэрэг хамгаалах 2 төрийн албан хаагчийг хамруулах боломжтой байна.

Тэтгэлгийн хүрээнд визийн зардал, ирэх очих замын зардал, дотуур байрны зардал, амжиргааны зардал, эрүүл мэндийн даатгал багтсан болно.

Иймд харьяалах нутаг дэвсгэр, салбарын байгууллагад нэгээс дээш жил ажиллаж буй англи хэлний APTIS-B1, IELTS-4.0, TOEFL PBT-437, TOEFL IBT-41 гэсэн түвшний аль нэгээс доошгүй оноотой, орос хэлээр академик түвшинд ойлгох чадвартай 2 хүртэл төрийн жинхэнэ албан хаагчийн материалыг 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд ирүүлнэ үү.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет,
- Нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар,
- "Тус академид орохыг хүссэн таван шалтгаан" сэдвээр орос хэл дээр 500 үгэнд багтаан бичсэн эссе,
- "Бүс нутгаа өрсөлдөөнд чиглүүлэн хөгжүүлэх арга замууд" сэдвээр орос хэл дээр 500 үгэнд багтаан бичсэн эссе,
- Томилох эрх бүхий этгээдийн нэр дэвшүүлэх тухай албан бичиг.

Ирүүлсэн материалыг хянаж 2017 оны 07 дугаар сарын 10-27-ны хооронд Казакстаны талд хүргүүлэх бөгөөд 08 дугаар сарын 15-22-ны хооронд нэр дэвшигч өөрийн зардлаар тус академид очиж ярилцлагын шалгалт, тохиолдол судлах (case study) шалгалтыг англи, казак, орос хэлний аль нэгээр өгөх шаардлагатайг анхаарна уу.

17003694

Энэхүү сургалтад яам, агентлагийн төв аппартын албан хаагчид хамаарахгүй бөгөөд аймаг, нийслэлийн харъяаны нутгийн захиргааны албан хаагчидад хамааралтай болно.

Холбогдох мэдээллийг хавсаргав.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА  Б.ЦОГОО